



НИЙСЛЭЛИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2010 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 31

Улаанбаатар хот

“Замын хөдөлгөөний удирдлагын төв”  
НӨҮГ байгуулах тухай

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын “ж” заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 77 дугаар зүйл, “Улаанбаатар хотын замын хөдөлгөөнийг хянах систем” төслийн зээлийн гэрээ болон Засгийн газар хоорондын тохиролцооны баримт бичгийг соёрхон батлах тухай хуулийн 1 дүгээр зүйл, Нийслэлийн Засаг даргын 2010 оны 1/333 тоот албан бичгээр өргөн мэдүүлсэн саналыг үндэслэн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. “Замын хөдөлгөөний удирдлагын төв” НӨҮГ байгуулсугай.

Хоёр. “Замын хөдөлгөөний удирдлагын төв” НӨҮГ-ын дүрэм, бүтэц, орон тоо, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан, шаардагдах зардлыг жил бүрийн нийслэлийн төсөвт тусгуулж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч /Г.Мөнхбаяр/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Т.БИЛЭГТ